



2018 оны 4-р сарын дугаар

- Мэдээ, мэдээлэл -

Зам, тээврийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо



Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Зам, тээврийн салбарын аварга шалгаруулах спортын таван төрөлт тэмцээн 4 сарын 7-ны өдрөөс эхлэн 24-ний өдрүүдэд болж өнгөрлөө. Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагуудын ажилтан, албан тушаалтнуудыг хамарсан тус спортын таван төрөлт тэмцээн нь идэвхтэй хөдөлгөөнөөр бие бялдраа чийрэгжүүлэх цаашлаад ажлын бүтээмж нэмэгдүүлэх, салбарын ажилтнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, спортын идэвхийг нэмэгдүүлэх зорилготой.

Тэмцээн Дартс, Снукер Бильярд, Хөлбөмбөг, Гар бөмбөг, Сагсан бөмбөг гэсэн төрлүүдээр зохион байгуулагдсан. Уг тэмцээнд ЗТХЯ-ны харьяа байгууллагын нийт 450 орчим тамирчид оролцсон ба "ГТХЗНТ" УТҮГ-ын албан хаагчид хурд хүч, авьяас чадвараараа өрсөлдөж амжилттай оролцлоо.





2018 оны 4-р сарын дугаар

- Мэдээ, мэдээлэл -

Төмөр замын харилцан мэдээлэл солилцох журмын төсөлд санал авч байна

Төмөр замын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох журмыг шинэчлэн боловсруулахтай холбогдож төмөр замын салбарын байгууллагууд болон нийт албан хаагч, ажилчдаас санал авч байна. Төмөр замын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох журам нь Монгол Улсын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Статистикийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм болон бусад эрх зүйн бичиг баримттай нийцүүлэн боловсруулагдсан. Та бүхэн www.rtcc.mrtd.gov.mn гэсэн хаягаар хандаж саналаа өгнө үү.

“Глобал навигацийн хиймэл дагуулын систем, Нийтийн хэрэглээний төмөр замын хүлээн авагч, Техникийн шаардлага” стандартуудыг орчууллаа

“O+P 941 - “Мэдээллийн сан болон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал” болон “ГОСТ Р 54115-2010-Глобал навигацийн хиймэл дагуулын систем, Нийтийн хэрэглээний төмөр замын хүлээн авагч, Техникийн шаардлага” стандартуудыг орчууллаа.

ТӨМӨР ЗАМЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА	
II хэвлэл “Оросын төмөр зам”-ын байгууллагын мэргэжилтнүүд болон ТЭХАБ-ын мэдээлэл ба кодчиллын талвар байнгын ажлын хэсгийг 2015 онд байгуулсан. 2015 оны 11-р сарын 17-19-ний өдрүүдэд сүүлийн уулзалтаар зөвшилцөж ТЭХАБ-ийн хороо байгуулагдав. ТЭХАБ-ын төмөр замуудын ерөнхий захирлуудын (Хариуцах төлөөлөгч) XXXI хурал 2016 оны 4-р сарын 25-29-ны өдрүүдэд болсон. Бүгд Найрамдах Киргиз Улс, Чолпон-Ата хот Хүчинтэй огноо: 2016 оны 4 дүгээр сарын 29 Тайлбар: 2005 оны 4-р сарын 29-ний 1-р хэвлэл хүчингүй болно.	O+P 941
МЭДЭЭЛЛИЙН САН БОЛОН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ДЭД БҮТЦИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	

2	
АГУУЛГА	
ТӨВЧИЛСӨН ҮГСНИЙ ЖАГСААЛТ	3
1 Нийтлэг үндэслэл	4
2 Үндсэн үүрэг, тодорхойлолт	6
3 МС ба МХХДБ мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх	9
3.1 Мэдээллийн нөөцийн үнэлэмжийг тодорхойлох	9
3.2 Аюул, сул талыг тодорхойлох	10
3.3 Эрсдэлийн шатжилгаа	12
3.4 Хариу арга хэмжээний үр нөлөөг үнэлэх	12
4 МС болон МХХДБ-ийн аюулгүй байдлын үндсэн аюул	14
4.1 Гадны аюулын гол эх сурвалж	14
4.2 Дотоодын аюулын гол эх сурвалж	14
4.3 МС болон МХХДБ-ийн аюулгүй байдалд заналхийлж болзошгүй үр дагавар	15
5 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хөтөлбөр	16
6 Мэдээллийн аюулгүй байдлын талвар байгууллагын үйл ажиллагаа ба хууль эрх зүйн хөтөлбөр	19
7 МС болон МХХДБ-ийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиглэл, технологи	21
7.1 Харгалзч болон нөөцийг адилгах, нэвтрэлт таниулах	21
7.2 МС болон МХХДБ-ийн хууль бус халдалтаас мэдээллийг хамгаалах арга зам	24
7.3 Мэдээллийн криптографийн хамгаалалтын арга	26
7.4 Сүлжээ хоорондын дэлгэц	28
7.5 Аюулгүй байдлын хяналт болон хяналтын хэрэгсэл	27
7.6 Үйлчлүүлэгч-сервер технологийн хамгаалалт	28
7.7 Виртуал эсрэг хамгаалалт	29
7.8 Мэдээллийн аюулгүй байдлын өслын удирдлагын хэрэгсэл ба систем	30
7.9 Интернет болон бусад нээлттэй сүлжээнүүдэд коллолын зангилааг аюулгүй болгох	30
7.10 МС болон МХХДБ-ийн бүрдэл хэсгүүдийг биет ноатролтоос хамгаалах	31
8 МС болон МХХДБ-ийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах системийн бүтэц хөгжил	32
8.1 МС болон төмөр замын аж ахуй нэгжийн мэдээллийн аюулгүй байдлын системийн үндсэн зорилтуул	32
8.2 Төмөр замын аж ахуй нэгжийн МС болон МХХДБ-ийн мэдээллийн аюулгүй байдлын үндсэн системийн бүтэц, чиг үүрэг	32
9 СИНВАЖЕ ХӨТӨЛӨХ	39




2018 оны 4-р сарын дугаар

- Мэдээ, мэдээлэл -

Төрийн ордонд “Хүчээ нэгтгээ” гэсэн уриатайгаар зохион байгуулагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хаврын хэлэлцүүлэгт амжилттай оролцлоо.

Хэлэлцүүлгийг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх нээж үг хэлж, Улсын Их хурлын дарга М.Энхболдыг мэндчилгээг УИХ-ын даргын Хуулийн бодлогын зөвлөх Р.Болд уншиж сонсгов. Төрийн ордны “Их танхим”-д үдээс өмнө болсон нэгдсэн хуралдаанаар “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” илтгэлийг Монгол улсын сайд, ЗГХЭГ-ийн дарга Г.Занданшатар, “Татварын хуулийн шинэчлэл” илтгэлийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар тавьж хэлэлцүүлэв. Дээрх сэдвүүдтэй холбогдуулан хэлэлцүүлэгт оролцсон хүмүүс санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, илтгэгч болон панелистуудаас тодорхой асуулт асууж, хариулт тайлбар авсан юм.





2018 оны 4-р сарын дугаар

Суурь бүтцийн 2018 оны 4-р сарын тасалдлын тайлан мэдээ

Зурмагийн тасалдал

2018 оны 4-р сард нийт 154 тасалдал, 169,4 галт тэрэг цагийн барилт үүсэж, 20,18 сая төгрөгийн хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:



Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 74-н нэгж буюу 92,5%, 79,1-н цаг буюу 87,5%-иар, хохирлын хэмжээ 10,04 сая төгрөг буюу 99%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.





2018 оны 4-р сарын дугаар

- Мэдээ, мэдээлэл -

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг төвийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлээ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг төвийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлээ. Уг аяны хүрээнд Хан-Уул дүүргийн Улаан загалмайн хороотой хамтарч эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ сэдэвт сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж албан хаагчдад мэдээлэл хүргэлээ.



Дархлаа сэргээх витаминжуулалтын аян зохион байгууллаа

Урин цаг ирж байгаатай холбогдуулан хүний биеийн дархлаа сульдаж халдварт өвчинд өртөмтгий болдогтой холбогдуулан ханиад томуу болон амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлааг сайжруулах зорилгоор витаминжуулалтын аяныг зохион байгууллаа. Аливаа өвчнийг туссаных нь дараа биш тусахаасаа өмнө сэргийлж байх нь хамгийн зөв алхам. Ямар ч өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгийн энгийн арга бол дархлааны системийн үйл ажиллагааг дэмжих явдал юм. Хүний ажлын бүтээмж эрүүл мэндтэй салшгүй холбоотой байдаг учраас төвийн нийт ажилтан, албан хаагчдыг витаминжууллаа.





2018 оны 4-р сарын дугаар

- Мэдээ, мэдээлэл -

Талархал аян зохион байгууллаа

Төвийн хэмжээнд талархал аяныг зохион байгууллаа. Уг аянаар төвийн ажилтан албан хаагчил нэг нэгэндээ талархсан сэтгэлээ бичгээр илэрхийлж урам зориг хайрлалаа.



“Төрийн болон албаны нууцын тухай хууль” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Төрийн болон албаны нууцыг хамгаалах эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийг 2016 оноос эхлэн мөрдөж байна. Мөн үр ашигтай, үр дүнтэй аргаар авилгалаас урьдчилан сэргийлэх, тэмцэх аргыг дэмжих, бэхжүүлэх Олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг хөгжүүлэх, хөнгөвчлөх, дэмжих Төрийн шударга, хариуцлагатай удирдлагыг бий болгох зорилготойгоор “Авлигын шалтгаан, үр дагавар” -ийг сурталчлах мэдээллийн арга хэмжээг зохион байгууллаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчилж мэдээлэл хүргэлээ



“Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчилж мэдээлэл хүргэлээ. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн мэдлэг болон жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд албан хаагчдад зөв ойлголт, эерэг хандлагыг төлөвшүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд нэгдсэн мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах нь чухал үүрэгтэй юм.



E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

2018 оны 4-р сарын дугаар

- Мэдээ, мэдээлэл -




Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагуудын хоногийн болон сарын статистик мэдээг салбарын мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байна. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлтийн мэдээ
- Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ /өссөн дүнгээр/
- Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/
- Дамжин өнгөрөх ачааны мэдээ /чиглэл, зуучлагч, төрлөөр, өссөн дүнгээр/
- Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ /чиглэл, зуучлагчаар, өссөн дүнгээр/
- Зорчигч тээвэрлэлтийн мэдээ
- Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын мэдээнүүд багтаж байна.

Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлүүдийн 4-р сарын дугааруудыг татаж авах боломжтой

2018 оны дөрөвдүгээр сард Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлийн 4-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrt.d.gov.mn цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэлээ.





🏠 Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
3-р хороо, Б.Шаравын гудамж-6
Хан-Уул цамхаг 8 давхар



2018 оны 4-р сарын дугаар

-Ярилцлага-



Т. Ариунбаатар: Олон улсын жишигт нийцүүлэн төмөр замын тээврийн салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна

- Сайн байна уу? Энэ өдрийн мэнд хүргэе. Миний урилгыг хүлээн авсанд баярлалаа.

Баярлалаа. Уншигчиддаа энэ өдрийн мэнд хүргэе.

- “ГТХЗНТ” УТҮГ нь ямар зорилго, чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг вэ? Танай төвийн талаархи мэдээллийг хүргэвэл...

Дэлхийн төмөр замын сүлжээтэй дэлхийн бүх улс орнуудад Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв бий. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны тогтоолоор байгуулагдсан “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй, шуурхай, найдвартай, үр ашигтай удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх зорилготой ажилладаг. Товчхондоо төмөр замын тээвэрлэлт, галт тэрэгний хөдөлгөөнийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хамгийн ашигтай хувилбараар, аюулгүй, шуурхай богино зайд яаж ажиллуулах вэ гэдэг нь бидний хүлээх үүрэг гэж ойлгож болно. Монгол Улсын төмөр замын тээврийн салбарт Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг, “Монголын төмөр зам” ТӨХК, “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Гашуунсухайтын төмөр зам” ХХК зэрэг суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч 120 гаруй байгууллагууд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнээс гадна Монгол улсад уул уурхайн, хувь, хувьсгалын төмөр замууд шинээр нэмэгдэж байна. Тэр утгаараа төмөр замын байгууллагуудын галт



2018 оны 4-р сарын дугаар

-Ярилцлага-

тэрэгний хөдөлгөөнийг үр ашигтайгаар уялдуулан зохицуулах, галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг боловсронгуй болгох, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, хангалтыг сайжруулах, салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтлөж ажиллахыг бид чухалчилдаг. Төмөр замын салбар өргөжин тэлэхийн хэрээр адил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хоорондын үйл ажиллагааг зохицуулах нэгдсэн төвийн үүрэг оролцоо зайлшгүй шаардлагатай болсон. Иймд өнөөгийн хууль, эрх зүйн орчин, төмөр замын салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг хуулийн орчинд үйл ажиллагаа явуулах байгууллага нь “ГТХЗНТ” юм.

- “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг байхад Хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв ямар хэрэгтэй юм бэ гэх зөрчилтэй ярианууд их байдаг. Энэ талаар таниас тодруулмаар байна...

“УБТЗ”, “МТЗ” нь төрийн оролцоотой байгууллага боловч ашгийн төлөөх учраас компаний тухай хуулиар зохицуулагддаг. Гэхдээ манай төв байгуулагдахаас өмнө “Улаанбаатар төмөр зам” гэсэн ганц байгууллага энэ бүгдийг хийж ирсэн. Гэтэл УБТЗ маань 2 орны хувь нийлүүлсэн нийгэмлэг шүү дээ. Тэгэхээр төрөөс төмөр замын бодлого хэрэгжүүлэх ёстой. Тэр ч утгаараа манайд “УБТЗ” “ХНН”, “МТЗ”, “ТӨХК” “БТЕГ” ХХК төрийн болон хувийн гурван ч компани төмөр замын тээвэрт оролцож байна. Монгол улсаар өдөрт дамжин өнгөрч байгаа галт тэрэг, транзит, тээвэр, стратегийн болон нүүрсний тээвэр, арилжааны галт тэргүүдийн зохицуулалтыг хийх, төмөр замын байгууллагуудын хоорондын тэгш эрх, тээврийн чиглэлийн үйлчилгээний шударга өрсөлдөөнийг бий болгохын төлөөх ажиллагааг төрөөс хийх шаардлагатай болсон.

- Энэ оны онд хийхээр төлөвлөсөн төвийн ажлуудаасаа дурдвал...

Төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах, холбогдох байгууллага, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, төмөр замын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгохоор ажиллаж байна. Мөн Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, бүртгэх, MNS 6630-3:2016 стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дугаарлалтыг шинэчлэх, Улсын хэмжээнд ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүн, салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх ажлыг зохион байгуулна. Түүнээс гадна Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгох нь маш чухал байна. УБТЗ, МТЗ, БТЕГ ХХК болон суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний үйл ажиллагаа, ачилт, буулгалт, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын байдалтай цаг тухай бүрт газар дээр нь танилцаж галт тэрэг солилцоонд дүн шинжилгээ хийж ажиллана. Мөн төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж зөвлөгөөн уулзалтуудыг тогтмол зохион байгуулах замаар олон улс, орон нутагт хүртээмжтэй төмөр замын тээврийн үйлчилгээг үзүүлнэ.



2018 оны 4-р сарын дугаар

-Ярилцлага-

- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн ирээдүйг хэрхэн төсөөлж ямар үйл явцтайгаар хөгжүүлэх вэ?

Ирээдүйд үр ашиг бүхий тээврийн оновчтой нэгдсэн систем бий болж орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтэрч салбарын хөгжил шинэ төвшинд хүрнэ. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв Монгол улсын нутаг дэвсгэр дээрх төмөр замаар хэний галт тэрэг, хаана явж байгааг шууд хянаж, зохицуулж ажилладаг болно. Түүнчлэн төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож 2 хөрштэйгөө цаашлаад олон улсын бусад улс орнуудтай өрсөлдөхүйц хэмжээнд ажиллана.

- Таны хэлснээр төв ажиллахад мэдээлэл системийн техник технологи чухал үүрэгтэй юм байна аа даа...

Тийм ээ. “ГТХЗНТ”-ийг мэдээлэл шинжилгээний цогц систем дээр үндэслэн 3 үе шаттайгаар хөгжүүлнэ. Эхний шатанд бид төмөр замын салбарын мэдээлэл дамжуулах нэгдсэн сүлжээг үүсгэн мэдээлэл-лавлагааны систем боловсруулж үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. Хоёрт мэдээлэл-төлөвлөлтийн систем боловсруулж үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. Гуравт урьдчилсан-таамаглалын /прогноз/ систем боловсруулж үйл ажиллагаанд нэвтрүүлж мэдээллийн-удирдлагын системийг бий болгоно. Мөн эрх зүйн зохицуулалтаар хангах асуудал байна. Манай төвд яагаад мэдээлэл өгөх ёстой юм бэ, ямар арга замаар мэдээллээ өгөх юм бэ гэдэг зүйл хууль журманд заагдсан байх ёстой. Бид нар өнөөдөр мэдээлэлтэй холбоотой хөдөлгөөн зохицуулалтын журам, мэдээлэл солилцох журам, хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөлтийн журмуудыг хэрэгжүүлж байна. Дээрээс нь гэрчилгээжүүлэлтийн мэдээллийг өөрийнхөө бааз болгохоор ажиллаж байна. Мэдээллүүдээ цуглуулж, боловсруулсан цогц мэдээлэл лавлагааны үйл ажиллагааг явуулж хэрэглэгчдийг болоод яам, төмөр замын байгууллагуудыг мэдээллээр хангана. Хамгийн том хүчин зүйл нь мэдээллүүд дээрээ үндэслэж төмөр замын ирээдүйн үйл ажиллагааг төлөвлөх юм. Яг одоогийн байдлаар бидэнд мэдээллүүдийг шууд татаж авдаг программ хангамж байхгүй. Техникийн боломжоо хараахан бүрдүүлж амжаагүй байна. Цаашлаад одоо байгаа төмөр замуудаасаа гадна ирээдүйд бий болох төмөр замуудын техникийн боломж болон эрх зүйн орчинг бий болгох асуудал болон ТЭЗҮ-тэй холбоотой мөнгө санхүүгийн асуудал яригдана. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төв рүү мэдээлэл дамжуулах техникийн шийдэл, техник эдийн засгийн үндэслэл хэрэгтэй байна. Бид нар ТЭЗҮ хийх талаар холбогдох байгууллагуудтай уулзаад явж байгаа. ТЭЗҮ дээр дараа дараагийн үе шатууд илүү тодорхой болно. Бид өнөөдөр мэдээллийн бааз үүсгэх ажлаа эхлүүлчихсэн цаашдаа ямар үр дүнд хүрэхээ тодорхойлоод ажиллаж байна.

- Сүүлийн үед төмөр замын салбарын орчин үеийн хөгжлийн талаар их яригдах болсон. Энэ талаар та ямар бодолтой байна вэ?

Монгол улсын эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа энэ үед төмөр замын тээврийн үйлчилгээний зах зээл тэлэх боломжтой. Ялангуяа далайд гарцгүй манай улсын хувьд төмөр



2018 оны 4-р сарын дугаар

-Ярилцлага-

замын тээврийн үйлчилгээ хөгжих нөөц хангалттай бий. Төмөр замын хөгжил нь Монгол улсын ДНБ-ийг өсгөх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зэргээр нийт эдийн засгийн өсөлтөд олон талаар хувь нэмэр оруулна гэж харж байгаа. Олон улсад төмөр замын тээвэрт дахин анхаарал тавьснаар эдийн засагт бүхэлд нь эерэг үр нөлөө үзүүлнэ. Төмөр замын тээвэрт хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалт татвал зах зээлийн өрсөлдөөн бий болж хөгжих боломжтой. Өнөөдөр ганц байгууллага монополийдож ажилт, буулгалт, тээвэрлэлт зэрэг бүх зүйлийг хийж байна гэж шүүмжилдэг. Тиймээс олон улсын жишигт нийцүүлэн төмөр замын тээврийн салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

- Төмөр замын тээврийн салбарын бодлогын талаар дорвитой нэгдмэл судалгаа Монгол улсын хэмжээнд байдаггүй гэсэн шүүмж байдаг. Тэр утгаараа мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх дээр анхаарч байгаа байх...

Тийм ээ. Манай хамт олон салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээг өргөжүүлж Төмөр замын салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний төслүүдийг боловсруулан ажилласан. Ерөнхийдөө судалгааны ажилд ашиглагдах мэдээ, мэдээллийг Монгол Улсын болон олон улсын төмөр замын байгууллагын үүсэл хөгжил, зорчигч тээврийн ангилал, ачаа тээврийн төрөл, өрсөлдөх чадвар зэрэг материалыг орчуулж, боловсруулж олон судалгааны ажлууд дээр ажиллаж байна. Ямар ч салбарын хөгжил судалгаан дээр тулгуурладаг. Тэр утгаараа бид төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ. Нэгдсэн мэдээллийн сантай болсноороо төмөр замын тээвэрлэлтийг зөв зохион байгуулахаас эхлээд маш олон давуу талтайгаас гадна төмөр замын салбарын хэтийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах юм. Мөн мэдээллийн нэгдсэн сантай болсноор төмөр замын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудыг мэдээллээр тогтмол хангаж чадна. Энэ нь байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд чухал нөлөө үзүүлнэ.

- “Төмөр замын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн” удахгүй зохион байгуулагдана гэж сонссон...

Удирдах ажилтны зөвлөгөөнд салбарын төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, төмөр замын салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын удирдах ажилтнуудын төлөөлөл оролцоно. Зөвлөгөөнөөр салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв, чиг хандлага, зорилтын талаар хэлэлцэх бөгөөд чанар стандартыг сайжруулах чиглэлээр Төмөр замын тухай хуульд орсон өөрчлөлт, түүнтэй холбогдон гарах журмууд, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэж байгаа ажлууд, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар холбогдох байгууллагуудын төлөөллүүд илтгэл тавина. Би ч мөн холбогдох сэдвийн дагуу илтгэл тавина. Удирдах ажилтны зөвлөгөөнөөр төмөр замын салбарын төлөөллүүд санал солилцож тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх арга замыг гаргана гэдэгт итгэлтэй байна.